

**ХОВД АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЭГИЙН ГАЗРЫН  
2018-2019 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ**

Нэг. Шалгалтын зорилго

Аймгийн Засаг даргын баталсан 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар удирдамжийн дагуу Ховд аймгийн Мал эмнэлэгийн газрын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын байдал, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэнд дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан ажиллахад оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт, аудитын албаны Улсын ахлах байцаагч Ц.Бадрал, Улсын байцаагч П.Мягмартүвшин нар 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хяналт шалгалтаар ажиллав.

Гурав. Шалгалтанд хамрагдсан асуудал

Тус байгууллагын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагааг Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн болон бусад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, үндсэн баримт материал, тайлан тэнцэлд тулгуурлан явуулав.

Дөрөв. Шалгалтанд хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол улсын бусад хууль эрх зүйн актуудыг удирдлага болгон ажил үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэн

улсын төсвөөс батлагдсан төсвийн санхүүжилтийг зарцуулж, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулж иржээ.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоол, ХХААХҮЯ-ны сайдын А/174 дүгээр тушаалаар улс, аймаг, суманд бүх шатны мал эмнэлэгийн байгууллага байгуулагдаж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгосонтой холбогдуулан Мал эмнэлгийн ерөнхий газраас “Малчинд ойрхон Мал эмнэлэг” зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Ховд аймгийн Мал эмнэлгийн газар нь 2019 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”, “Монгол мал” үндэсний хөтөлбөр, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиуд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүд болон бодлогын баримт бичгүүдийг үндсэн үйл ажиллагаандаа мөрдөж, төр засгийн бодлого, зорилтын хүрээнд удирдах дээд байгууллагаас гарсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж, шинэ тутам байгуулагдсан аймаг, сум орон нутгийн мал эмнэлгийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, бэхжүүлэн хөгжүүлэх, мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, ард иргэдийг эрүүл хүнсээр хангах зорилтыг тэргүүлэх чиглэл болгон ажилласан байна.

Тус газар нь 2019 онд Захиргаа санхүүгийн алба, Малын эрүүл мэндийн алба, Мал эмнэлэгийн лаборатори, Сумдын мал эмнэлэгийн тасаг гэсэн 4 алба, тасагтай, хувийн хэвшлийн 52 мал эмнэлэгийн үйлчилгээний нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/174 дүгээр тушаалын дагуу 2019 онд Ховд аймгийн мал эмнэлэгийн газар нь 52 орон тоотойгоор ажиллахаар батлагдсанаас 51 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж иржээ. Ховд аймгийн Дуут сумын мал эмнэлэгийн тасгийн улсын байцаагчийн орон тоонд хүн томилогдоогүй байгаатай холбоотой 1 орон тоо хэмнэн ажилласан байна.

Тав. Төсвийн бүрдүүлэлт, зарлага санхүүжилтийн талаар

Ховд аймгийн Мал эмнэлэгийн газар нь 2019 онд улсын төсвөөс 518913.3 мянган төгрөг, өөрийн орлогоор 3000.0 мянган төгрөг, нийт 521913.3 мянган төгрөг бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 869858.0 мянган төгрөг, өөрийн орлогоор 2432.6 мянган төгрөг, нийт 872294.6 мянган төгрөг бүрдүүлж, зарцуулсан байна.

2019 онд нийт зардлын 10.3 хувийг цалин хөлсний зардалд, 1.3 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 4 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 6.4 хувийг хангамж бараа материалын зардалд, 7.4 хувийг нормативт зардалд, 9.1 хувийг эд хогшил, урсгал засварын зардалд, 61.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжинд, 0.2 хувийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд тус тус зарцуулсан байна.

2019 онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 14739.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 23111.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 173696.4 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 78254.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 61250.0 мянган төгрөгөөр, нийт 351051.5 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн. Харин цэвэр бохир усны зардлыг 549.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 125.0 мянган төгрөгөөр, нийт 674.2 мянган төгрөгөөр хэмнэж, 2019 оны батлагдсан төсвийг 350377.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн ажиллажээ.

2019 онд Нэмэлт санхүүжилтийн дансаар сумдын Засаг даргын тамгын газрын вакцины мөнгө 187421.7 мянган төгрөг, Мал эмнэлэг үржлийн газраас бруцеллёз өвчний үйлчилгээний хөлс 115358.2 мянган төгрөг, Хөшөөт хөгжлийн сангаас 15200.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 30000.0 мянган төгрөг, Засаг дарга данснаас захирамжаар 18700.0 мянган төгрөг, Ариун цэврийн төв лабораториос 3243.2 мянган төгрөг, мал эмнэлэг үржлийн газраас боом, галзуу өвчний үйлчилгээний хөлс 21118.3 мянган төгрөг, Мал эмнэлэгийн холбооноос 3000.0 мянган төгрөг, нийт 394041.6 мянган төгрөгийн орлого оржээ.

Эм бэлдмэлийн үнэ 207343.9 мянган төгрөгийг эмийн компаниудад, бруцеллёзын тарилгын хөлс 73017.2 мянган төгрөгийг сумдын мал эмнэлэгийн нэгжүүдэд, шатахууны зардалд 14000.0 мянган төгрөгийг, галзуу, боом өвчний тарилгын хөлс 21118.3 мянган төгрөгийг сумдын мал эмнэлэгийн нэгжүүдэд, мал эмнэлэгийн багаж хэрэгслийн зардалд 16075.5 мянган төгрөгийг, сургалтын зардалд 4750.0 мянган төгрөгийг, тэжээвэр нохой, муурын эрүүл мэндийн үйлчилгээний зардалд 6511.7 мянган төгрөг, томилолт, бичиг хэрэг, урсгал засвар

болон бусад зардлуудад 26889.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 24589.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд 24603.2 мянган төгрөгийн авлагатай байгаагаас 24589.6 мянган төгрөгийн татан төвлөрүүлсэн орлогыг, хувь хүмүүсээс авах авлага 13.6 мянган төгрөгийг бүртгэжээ.

Тайлант онд өр төлбөр үүсгээгүй байна.

Тус газар нь 2019 онд шинээр байгуулагдсантай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 12 сарын 10-ны өдрийн 513 тоот тогтоолын дагуу 1179070.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А-209 тоот тушаалаар 182962.2 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан бөгөөд тус онд 81927.6 мянган төгрөгийн хөрөнгийг шинээр худалдан авсан, 370375.5 мянган төгрөгийн хөрөнгийг сумдын Засаг даргын тамгын газрын балансаас аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 93 тоот тогтоолоор шилжүүлэн авсан, 83036.6 төгрөгийн хөрөнгийг Мал эмнэлэгийн ерөнхий газраас шилжүүлэн авч бүртгэж, тайлант хугацаанд 23292.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, хуримтлагдсан элэгдэл 986194.9 мянган төгрөг болсон байна.

Тус газар нь жилийн эцсийн санхүүгийн тайланд 1714410.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 728215.4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг тусгажээ.

2019 онд тус газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 4 ажил гүйцэтгүүлэхээр 142200.0 мянган төгрөгийн тендер зарлаж ажиллажээ.

2019 онд хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын ажлуудын дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр харуулбал:

ДД	Ажил үйлчилгээний нэр	Төсөвт өртөг	Тендер шалгаруулалтын арга	Шалгарсан ААН, байгууллага	Хүлээлгэн өгсөн эсэх
1	Барилгын урсгал засварын ажил	49500000	Онцгой комиссын шийдвэрээр /Харьцуулалт /	Баруун жонон ХХК	Өгсөн. /ажил дутуу/
2	Дуудлага үйлчилгээ яаралтай тусламжийн иж бүрдэл	47500000	Харьцуулалт	Спарровс-Т ХХК	Өгсөн. /бараа дутуу/
3	Лабортортийн багаж оношлуур нийлүүлэх	15200000	Харьцуулалт	Монветмед ХХК Монбиофарм ХХК	Өгсөн.

4	Конторын барилгын зураг төсөв хийх	30000000	Харьцуулалт	Алтайн газрын хүч ХХК	Өгсөн.
5	Тавилга, ширээ сандал худалдан авах	9966450	Шууд худалдан авалт	Хашхан ХХК	Өгсөн.
6	Компьютер худалдан авах	9991300	Шууд худалдан авалт	Ньюсоник ХХК	Өгсөн.
7	Компьютер тоног төхөөрөмж	3828000	Шууд худалдан авалт	Ньюсоник ХХК	Өгсөн.
ДҮН		165985750			

Конторын барилгын зураг төсөв хийх, дуудлага үйлчилгээ яаралтай тусламжийн иж бүрдэл нийлүүлэх, Лаборторийн багаж оношлуур нийлүүлэх, тавилга, ширээ сандал худалдан авах, Компьютер тоног төхөөрөмж худалдан авах ажлуудыг комисс томилон хүлээн авсан байна.

2019 онд Ховд аймгийн мал эмнэлэгийн газар Малын эрүүл мэндийг хангах чиглэлээр 11 төрлийн вакциныг 1989105 /давхардсан тоогоор/ мал, амьтанд тарьжээ. Дэлгэрэнгүй хүснэгтээр харуулбал:

№	Нэр төрөл	Малын тоо		Нийт малын тоо	Зарцуулсан вакцин
		Бог	Бод		
1	Дотрын халдварт хордлого	363663		363663	1806 литр
2	Дуут хавдар	-	30595	30595	147.5 литр
3	Цусан халдварт вакцин	35670	28488	64158	873 литр
4	Коли бактериоз	20594		20594	172.8 литр
5	Томуу		6881	6881	41.5 литр
6	Сохор догол	343350		343350	1938 литр
7	Шөвөг яр	320355		320355	374.6 тун
8	Сахуу		32552	32552	519 литр
9	Боом /Улсын төсвөөс/	43846	18506	62352	40429 мл
10	Галзуу /Улсын төсвөөс/	34860	28053	62913	62913 тун
11	Бруцеллэз	637671	44021	681692	410.6 тун
ДҮН		1800009	189096	1989105	

Ховд аймгийн төл малд таригдсан бруцеллэз өвчний вакцинжуулалтын түвшин тогтоох тандалт шинжилгээг 2019 оны 11 дүгээр сард зохион байгуулж 17 сумын 68 багийн 335 өрхийн 693 тугал, 1590 хурга, 1658 ишиг, нийт 3941 малаас дээж авч, 354 тугал, 878 хурга, 853 ишиг, нийт 2085 малд шинжилгээний эерэг дүн үзүүлсэн байна. Иймд 104454850 төгрөгийн үйлчилгээний хөлс Мал эмнэлэгийн ерөнхий газраас ирснээс 79865241.8 төгрөгийг мал эмнэлэгийн үйлчилгээний нэгжүүдэд олгож, 24589608.2 төгрөгийн тарилгын хөлсийг олголгүй суутган тооцсон байна.

А. Ховд аймгийн Мал эмнэлэгийн газар нь аймгийн ИТХ-аар баталсан 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд Малын эрүүл мэнд аймгийн дэд хөтөлбөрт 30 сая, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 10.7 сая, нохой муурыг бүртгэлжүүлэх, гэрчилгээжүүлэх ажилд 8.0 сая төгрөг, Хөшөөт хөгжлийн сангаас 15.2 сая төгрөгийг тус тус батлуулж, нийт 63.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлж, Засаг даргын захирамжаар хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэн авч, зорилтот ажлуудыг хийж хэрэгжүүлжээ.

В. Монгол улсын “Малын эмч нарын анхдугаар их хурал”-д Ховд аймгаас 33 төлөөлөгч оролцож, Монгол улсын мал эмнэлгийн салбарын бодлого, цаашдын зорилтыг хэлэлцэн батлалцах үйл ажиллагаанд оролцож, Ховд аймагт зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг”, “Шинэ ховд Хөрөнгө оруулагчдын 2 дугаар чуулганд оролцон, салбарын оролцоог хангаж ажиллаласан байна.

С. БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөдөө аж ахуйн их сургуульд зохион байгуулсан “Монгол улсын мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх мэргэжлийн 1 сарын сургалтанд лабораторийн эрхлэгч эмчийг оролцуулж, мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд анхаарч ажиллажээ.

Д. Ногоон алт, малын эрүүл мэнд төслөөс тус аймгийн Мөнххайрхан, Дуут, Чандмань сумуудад малын маханд эмийн үлдэгдлийг тодорхойлох, МАА-н бүтээгдэхүүний гарал үүслийн мөшгих тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд хамтран ажиллаж, 2019 оны 10 дугаар сараас эхлэн мөшгих тогтолцоо буюу мал эмнэлгийн гэрчилгээний системийг Ховд аймгийн бүх суманд нэвтрүүлж эхлээд байна. Энэ үйл ажиллагаанд Ногоон алт-Малын эрүүл мэнд төслөөс 51 хувь буюу 84.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 2020 онд 49 хувь буюу 81.4 сая төгрөгийг санхүүжүүлж, Мал эмнэлгийн гэрчилгээний системийг нэвтрүүлэхэд шаардлагатай компьютер, техник тоног төхөөрөмжийг “Дижитал медик” ХХК нийлүүлж, энэхүү ажил тус аймагт амжилттай хэрэгжиж эхэлжээ.

Е. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын эксперт доктор Надов Галон, доктор Сузан Мунстерман болон МЭЕГ-ын төлөөлөгчийг Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаатай танилцуулж, үнэлгээ хийлгэж, Дарви сумын мал эмнэлгийн тасаг, эм ханган нийлүүлэлтийн “Арнай хоршоо”-ны эмийн сан, “Жаргалант шанд” мах боловсруулах үйлдвэр, “Политехник коллежийн” үйл ажиллагаатай тус тус танилцуулж үнэлгээнд тус аймаг амжилттай шалгагдсан байна.

Долоо. Өмнөх шалгалтын талаар

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас өгсөн байна.

2019 оны санхүүгийн талангийн аудитаар тухайн онд шилэн дансны нэгдсэн системд мэдээллүүдээ шивж оруулсан боловч баталгаажуулаагүй, хугацаа хоцроосон, тууврын хөлс олгосон 3060.0 мянган төгрөгийн анхан шатны баримт дутуу, гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй олгосон зэрэг зөрчил дутагдлууд илрүүлж зөвлөмж өгсөн байна. Мөн аудитыг хэрэгжүүлэх явцад урсгал засвар хийсэн 49500.0 мянган төгрөгийг капиталжуулж үндсэн хөрөнгөд нэмэгдүүлээгүй байсныг залруулга хийж капиталжуулсан, нэмэлт данснаас татан төвлөрүүлсэн 24589.6 мянган төгрөгийн авлагаар бүртгүүлсэн, автомашины сэлбэг хэрэгсэлд 5396.1 мянган төгрөгийг зарцуулсан ба сэлбэг худалдан авахдаа өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэж дүгнэлт гаргаагүй зөрчилд нөхөн гаргуулж аудитын явцад залруулсан байна.

Мөн Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас сумдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Ховд аймгийн 6 сумын 13 мал эмнэлэгт мал эмнэлэгийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээний /Дотрын халдварт хордлого, Дуут хавдар, Цусан халдварт, Коли бактериоз, томуу 5 төрлийн өвчний вакцины/ зардалд 13159317 төгрөг илүү тооцон олгосон байсныг дээрх аж ахуй нэгжүүдээр төлүүлж, аймгийн төсөвт оруулахаар акт тогтоож, барагдуулан ажиллаж байна. Илүү санхүүжилт авсан аж ахуй нэгжүүдийг харуулбал:

ДД	Мал эмнэлэгийн нэр	Сум	Бог /400 төг/	Бод /300 төг/	Илүү олгосон санхүүжилт
1	Мэнд сүрэг	Алтай	520	9834	1194153
2	Алтайн өндөрлөг уулс	Алтай	195	5064	1462898
3	Алтай 5 сувд	Алтай	695	9200	760340
4	Гурвалжин тан	Буянт	6234	21990	2840000
5	Буянт оргих шим	Буянт	200	14000	380000
6	Хишиг сүрэг	Дарви	500	14400	932329
7	Малын ашиг	Дарви	1600	22600	517020
8	Сутайн төл таван эрдэнэ	Дарви	100	14112	722719
9	Сутайн төл таван эрдэнэ	Дарви	1100	14000	637306
10	Агваш арал	Дөргөн	1378	21880	2238816
11	Өлзий судаг	Мянгад	1232	4880	490468
12	Мөнххайрхан царцаа	Мөнххайрхан	98	15960	849171
13	Цэнхэрийн долгио	Мөнххайрхан	490	26720	134097
	ДҮН		14342	194640	15159317

Найм. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар

Энэ удаагийн шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрч байна. Үүнд:

1. Автомашины сэлбэг, хэрэгсэл, дугуй тавьж олгохдоо тооцоо бодоогүй нь Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг

2. Нягтлан бодогчийн цалинг ТҮ-7 дахь ангилал зэрэглэлийн дагуу цалинжуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт, Засгийн газрын 354 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтыг

3. 2019 онд тус газар нь Барилгын урсгал засварын ажил - 49500000 төгрөг, Дуудлага үйлчилгээ яаралтай тусламжийн иж бүрдэл - 47500000 төгрөг, Конторын барилгын зураг төсөв хийх - 30000000 төгрөгийн тендер шалгаруулалт хийсэн байна. Ингэхдээ тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтыг

4. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлүүд илэрч байна.

4.1 Дуудлага үйлчилгээ, яаралтай тусламжийн иж бүрдэл-47500000 төгрөгийн тендерийг шалгаруулахдаа яаралтай тусламжийн эм бэлдмэлийг 68 боодлыг авахаар техникийн тодорхойлолтод тусгаснаас тендерт оролцогч С ХХК нь захиалагчийн баталсан жишиг маягт болох үнийн саналын маягтаар саналаа ирүүлэхдээ 64 боодлыг нийлүүлэхээр тендер ирүүлсэн байхад шалгаруулж гэрээ байгуулсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.3 дахь заалтуудыг

4.2 Тендерт оролцогч С ХХК нь санал болгож буй үнийн дүнгийн 5%-ийн хөнгөлөлт үзүүлэхээр санал ирүүлсэн боловч үнэлгээний хорооны 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн дүгнэлтээр 47498000 төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгохоор захиалагчид хүргүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.1, 28.7.4 дэх заалтуудыг

4.3 Шүлхий өвчний түргэн оношлуур, галзуу өвчний түргэн оношлуур тус бүр 34 ширхэг авахаас тус бүр 10 ширхэг оношлуур хүлээн авч 48 ширхэг оношлуурыг гадаадаас авах боломжгүй болсон учраас оношлуурын оронд биксний хайрцаг авахаар тохиролцож, нийт 17 хайрцаг авахаас 8 ширхэг хайрцаг хүлээн аваагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалт, Мал эмнэлэгийн



дуудлага үйлчилгээний яаралтай тусламжийн иж бүрдэл нийлүүлэх гэрээний нөхцлийг

4.4 2019 онд барилгын урсгал засварын ажил хийлгэхээр Ховд аймгийн онцгой комиссын хурлын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэрийн дагуу Б ХХК-тай 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ажил гүйцэтгэх №01 дугаартай гэрээ байгуулсан, уг компани 2019 оны 10 сарын 22-ны өдөр 49500000 төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал ирүүлсэн байхад 50000000 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, онцгой комиссын шийдвэр, үнийн санал ирэхээс өмнө гэрээ байгуулсан, агуулахын засварыг одоогийн байдлаар бүрэн хийгээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалт, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1, 350.1.6 дахь заалт, 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ажил гүйцэтгэх №01 дугаартай гэрээний нөхцлийг

5. 2019 онд Жолооч Э, Улсын байцаагч П нар 9 сарын 11-17-ны өдрийн хооронд Дарви, Зэрэг, Мянгад, Чандмань, Дөргөн сумдаар ажилласан байхад 9 сарын 14-17-ны хооронд Мөст, Манхан, Буянт суманд ажилласнаар давхардуулан албан томилолт олгосон, 8 сард Жолооч Э, Халдвар судлаач Э, Мэргэжилтэн О нар Ховд аймгийн төв Жаргалант суманд ажилласан байхад тус бүр албан томилолт олгосон, Жолооч Э 8 сарын 2-15-ны хооронд баруун сумдад ажилласан байхад 8 сарын 7-14-ны хооронд Орхон аймагт ажилласнаар томилолтын хуудсанд бичилт хийн албан томилолт олгосон, нийт 204000 төгрөгийн томилолтын зардал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалт, 2019 оны 6 дугаар тогтоолын 2.1, 2.4 дахь заалтуудыг

6. Дарга Б-д 2019 оны 12 дугаар сард анхан шатны баримтгүйгээр 300000 төгрөг шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтуудыг

7. Мал эмнэлэгийн газрын даргын 2019 оны А/46 дугаар тушаалаар нярвын дансанд 675000 төгрөгийг анхан шатны баримтгүйгээр шилжүүлсэн, няравын дансанд өнөөдрийн байдлаар бэлэн байхад тайлан тэнцэлд тусгаагүй, шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.1, 14.4.2 дахь заалтуудыг

8. 2019 оны 9,10,11 дүгээр сард Тархвар зүйч Ө-д 2 өдөр, О-д 1 өдөр, Б-д 1 өдөр, Б-д 3 өдөр, Улсын байцаагч П-д 4 өдрийн цалин хөлсийг тус тус ээлжийн амралттай байх хугацаанд тооцон, нийт 385712 төгрөг илүү олгосон нь

Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 55 дугаар зүйлийн 55.1 дэх заалтуудыг

9. Нярав /бичиг хэрэг/ Э-д Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 10 сарын 18-ны өдрийн А-174 тоот тушаалаар нярав /бичиг хэрэг/-ыг ТҮ-4-3 дугаар ангилал, зэрэглэлээр цалинжуулахаар тогтоосон байхад Газрын даргын Б/02 тоот тушаалаар ТҮ-5-1 дүгээр ангилал, зэрэглэлээр цалинжуулж, цалин хөлс 408627 төгрөг илүү олгосон нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 10 сарын 18-ны өдрийн А-174 тоот тушаал, Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтыг

10. 2019 онд Мал эмнэлэгийн ерөнхий газраас 521913.3 мянган төгрөгийн төсөв баталж өгсөн байхад тус газар нь батлагдсан төсөвт өөрчлөлт оруулалгүйгээр 350377.3 мянган төгрөгийн санхүүжилт нэмэгдүүлэн авч 872290.6 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1, 42.5 дахь заалтуудыг **/хавсралт №01-ээр дэлгэргүй харуулав/**

11. 2019 онд Х ХХК-аас халаагуурын үнэ 3600000 төгрөг шилжүүлсэн боловч түлш халаалтын зардлаас гаргаж зардлаар бүртгэсэн, 2020 онд үнэ төлбөргүйгээр хүлээн авснаар тайлагнаж, бүртгэж авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтууд, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг

12. Шатахуунтай холбоотой дараах зөрчил илэрч байна.

12.1 Шатахууны тооцоо боддоггүй, 2019 онд шатахууны талоны эх хувь баримтанд үдэгдээгүй, шатахууныг бараа материалын тайланд дутуу орлогод авч, зарлага гаргасан, хөдөө сумдын мал эмнэлэг үржлийн тасгийн шатахууны тооцоог бодож нягтлаагүй, бүртгэлээр тавих хяналт суларсан, анхан шатны баримтгүй гүйлгээ хийдэг, шатахуун түгээх станцтай сар бүр тооцоо хийгээгүй.

12.2 2019 оны 02 дугаар сарын 21-ны өдөр жолооч Э нь Буянт сумын цагаан эрэг гэдэг газар /30л дизель түлш зарцуулсан/ даргатай явж ажилласан гэх боловч тухайн үед Б нь Улаанбаатар хотод томилолтоор ажиллаж байсан, 2019 оны 03 дугаар сарын 08-ны өдөр Жолооч Э, Малын эмч Х нар замын хуудсаар дуудлагаар ажилласан /15л дизель түлш/ гэж бичсэн боловч дуудлагын журнал, бусад анхан шатны баримтаас зөрүүтэй, 2019 оны 05 дугаар сарын 29-ны өдөр Дарга Б нь Баян-Өлгий аймагт ажилласан гэж 48-50хоу автомашинд 50л АИ92 зарцуулсан боловч томилолт, удирдамжаар баталгаажаагүй, 2019 оны 06 сарын 20-24-ний өдрүүдэд жолооч Э нь 80л аи-92 шатахууныг замын хуудсанд бичихдээ томилолтоор ОХУ-д ажиллаж байсан дарга Б-ээр зуруулсан, Нягтлан бодогч Э нь 2019 оны 08 дугаар сард 60л шатахуун, 2019 оны 10 дугаар сард 75л аи-92

шатахууныг өөрийн автомашинд хийж хөдөө сумдаар ажилласан гэх бөгөөд удирдамж, томилолт, томилолтоор ажилласан тайлан байхгүй зэрэг, нийт шатахуунтай холбоотой 16435560 төгрөгийн тооцоог алдаатай бодсон, жолоочийн тооцоог үнэн зөв бодож баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, няравын тайланг стандартын дагуу гаргаагүй зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6 дахь заалтууд, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаал, Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалуудыг зөрчсөн байна.

13. 2019 онд нэмэлт санхүүжилтийн данснаас Э-ийн харилцах дансанд алба хаагчдын биеийн тамирын хувцасны үнэ 1020240 төгрөгийг аймгийн ИТХ-аар баталсан Эрүүл мал дэд хөтөлбөрөөс зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2018 оны 11 сарын 23-ны өдрийн 107 дугаар тогтоолыг

14. Хөрөнгө зарцуулах, зардал гаргах тушаал гаргаж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан бөгөөд тушаалд зарцуулах хөрөнгө, мөнгөний хэмжээг тусгаж өгөөгүй, архивын бичиг баримтуудыг стандартын дагуу эмх цэгцтэй, бүрэн үдэж архивлаагүй, төрийн албан хэрэг хөтлөлт, архивын стандарт, дүрэм, журмуудыг хангалтгүй мөрдөж ажилласан зэрэг зөрчил дутагдлууд илэрч байна.

Шалгалтаар Ховд аймгийн Мал эмнэлэгийн газарт 27944314 төгрөгийн зөрчил илрүүлж, 3998914 төгрөгийг аймгийн төсөвт оруулахаар шийдвэрлэж, улсын ахлах байцаагчийн акт тогтоож, 23945400 төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

#### Ес. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Ховд аймгийн Мал эмнэлэгийн газар нь 2020 оны 5 дугаар сарын байдлаар 13 төрлийн 59 мэдээ, тайланг шилэн дансны нэгдсэн системд байршуулахаас 51 мэдээг хугацаанд нь, 3 төрлийн 8 мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Харин 2019 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдалд Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас мэдээллүүдээ программд оруулсан боловч баталгаажуулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн тул нягтлан бодогчид зөвлөмж өгсөн байна.

#### Арав. Дүгнэлт

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийг НББОУСтандартын дагуу хөтөлж байгаа боловч түлш халаалт зэрэг зарим төрлийн зардлуудаас хөрөнгө бэлтгэж, зардлаар бүртгэсэн байна.

2019 онд Мал эмнэлэгийн газар нь шинээр байгуулагдсантай холбоотойгоор газрын үйл ажиллагааг тогтворжуулах, хүний нөөц, бааз суурийг бэхжүүлэхэд анхаарч 2019 оны үйл ажиллагааг чиглүүлж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

2019 онд төсөвт батлагдаагүй зардлуудыг дээд шатны байгууллагаас урсгал санхүүжилтээр авч зарцуулсан, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд, үр ашигтай төлөвлөж, зохион байгуулаагүй, төрийн худалдан авах ажиллагааны дүрэм журмуудыг хангалтгүй мөрдсөн байна.

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, Засгийн газраас тогтоосон цалингийн шатлал мөрдөөгүй, албан томилолтын зардлыг холбогдох журам зөрчин олгосон зөрчлүүд байгааг арилган, холбогдох хууль журмын хэрэгжилтэнд анхаарч ажиллах нь зүйтэй.

#### Арван нэг. Санал зөвлөмж

Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэх санал:

- Дуудлага үйлчилгээ, яаралтай тусламжийн иж бүрдэл-47500000 төгрөгийн тендерийг шалгаруулахдаа яаралтай тусламжийн эм бэлдмэлийг 68 боодлыг авахаар техникийн тодорхойлолтод тусгаснаас тендерт оролцогч С ХХК нь захиалагчийн баталсан жишиг маягт болох үнийн саналын маягтаар саналаа ирүүлэхдээ 64 боодлыг нийлүүлэхээр тендер ирүүлсэн байхад шалгаруулж гэрээ байгуулсан, тендерт оролцогч Спарровс-Т ХХК нь санал болгож буй үнийн дүнгийн 5%-ийн хөнгөлөлт үзүүлэхээр санал ирүүлсэн боловч үнэлгээний хорооны 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн дүгнэлтээр 47498000 төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгохоор захиалагчид хүргүүлсэн, шүлхий өвчний түргэн оношлуур, галзуу өвчний түргэн оношлуур тус бүр 24 ширхэгийг дутуу хүлээн авсан, гадаадаас авах боломжгүй болсон учраас оношлуурын оронд биксний хайрцаг авахаар тохиролцож, нийт 17 хайрцаг авахаас 8 ширхэг хайрцаг хүлээн аваагүй байгаа зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.3 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.7.1, 28.7.4 дэх заалтуудыг, Мал эмнэлэгийн дуудлага үйлчилгээний яаралтай тусламжийн иж бүрдэл нийлүүлэх 2019 оны 12 сарын 06-ны өдрийн №3 дугаартай гэрээний 4, 5 дахь заалтуудыг зөрчиж байх тул худалдан авах ажиллагааны улсын байцаагчаар шалгуулж, шийдвэрлүүлэх.

- 2019 онд барилгын урсгал засварын ажил хийлгэхээр Ховд аймгийн онцгой комиссын хурлын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэрийн дагуу Б

ХХК-тай 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ажил гүйцэтгэх №01 дугаартай гэрээ байгуулсан, уг компани 2019 оны 10 сарын 22-ны өдөр 49500000 төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал ирүүлсэн байхад 50000000 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, онцгой комиссын шийдвэр, үнийн санал ирэхээс өмнө гэрээ байгуулсан, агуулахын засварыг одоогийн байдлаар бүрэн хийгээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалт, Иргэний хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1, 350.1.6 дахь заалт, 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ажил гүйцэтгэх №01 дугаартай гэрээний 5.2.6 дахь заалтуудыг зөрчиж байх тул худалдан авах ажиллагааны улсын байцаагчаар шалгуулж, шийдвэрлүүлэх.

- Сумдын мал эмнэлэгийн тархвар зүйчдийн цалин хөлсний ангилал, зэрэглэлийг төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлд оруулах.
- Ховд аймгийн Мал эмнэлэгийн лабораторийг бүсийн лаборатори болгох.
- Мал эмнэлэгийн оффисын барилгын ажлыг яаралтай бариулах.

Мал эмнэлэгийн газарт цаашид авч хэрэгжүүлэх санал, зөвлөмж:

1. Бараа материалын тайланг үнэн, зөв, стандартын дагуу гаргаж байх.
2. Автомашины дугуй, аккумулятор, бусад хугацаатай эд анги, сэлбэг хэрэгслийн тооцоо бодох, шатахууны тооцоог үнэн зөв бодож хэвших, Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах.
3. Цалин хөлсийг хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудын хүрээнд зөв тогтоох, бодож олгох.
4. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, худалдан авах ажиллагааны журмуудад нийцүүлэн зохион байгуулах.
5. Ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл хангагдсны үндсэн дээр хийх, анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй ажил гүйлгээг тайланд тусгахгүй байх.
6. Төсвийн зохицуулалтыг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын тушаал, хууль, эрх зүйн актуудын хүрээнд хийх шаардлагатай.
7. Төрийн захиргааны албан тушаалтнуудын зэрэг дэвийн нэмэгдлийг олгохдоо 2020 оноос Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу шинэчлэн тогтоож олгох.

8. Шатахууны тооцоог сар бүр хийх, замын хуудсыг явсан өдөр, километр бүрээр бичих, жолоочийн тооцоог бодохдоо Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах.

9. Аймаг орон нутгаас санхүүжүүлж байгаа хөтөлбөрийн хөрөнгө мөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулах

10. Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын стандарт, дүрэм, журмуудыг мөрдөж ажиллах, ажилтны нийгмийн баталгааг хангах, тэтгэмж урамшуулал олгохдоо төсвийн шууд захирагчийн тушаал, шийдвэрийн дагуу олгож байх.

Шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авч, биелэлтийг 2020 оны 07 дугаар сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг хариуцуулав.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА